

БАТЛАВ:  
БАЙГАЛЬ ОРЧИН АЯЛАЛЖУУЛЧЛАЛЫН  
САЙД *Б.САИД* Б.БАТ-ЭРДЭНЭ

“ШИНЭ ХАРХОРУМ” ХОТЫН ХҮН АМЫН  
УНД АХУЙН ЭХ ҮҮСВЭРИЙГ ТОГТООХ ГАЗРЫН ДООРХ УСНЫ ЭРЭЛ-  
ХАЙГУУЛЫН СУДАЛГААНЫ АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 03 сарын 07-ны өдөр

Дугаар № 2023-ҮГ/11А Улаанбаатар хот

Судалгааны үе шат:	Газрын доорх усны эрэл-хайгуулын үе шат
Судалгаа явуулах хугацаа:	<ul style="list-style-type: none"> <li>- Судалгааны ажлыг гүйцэтгэх гэрээ байгуулсан өдрөөс хойш хуанлийн 90 хоногт газрын доорх усны эрлийн үе шатны судалгааг гүйцэтгэн, үр дүнг БОАЖЯ-ны Усны нөөцийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх;</li> <li>- Газрын доорх усны эрлийн үе шатны судалгааны үр дүнг зөвлөлөөр хэлэлцүүлж, холбогдох зөвлөмж авснаас хойш хуанлийн 150 хоногт газрын доорх усны хайгуулын үе шатны судалгааг гүйцэтгэн, үр дүнг БОАЖЯ-ны Усны нөөцийн зөвлөл болон Барилга хот байгуулалтын яамны Шинжлэх ухаан, техник технологийн зөвлөлөөр хэлэлцүүлж, үр дүнг баталгаажуулах;</li> </ul>
Судалгааны талбайн нэр, хамрах хүрээ:	Судалгаанд нийт 125,899.4 га бүхий 2 хэсэг талбайг хамруулах бөгөөд Өвөрхангай аймгийн Хархорин сум, Архангай аймгийн Хотонт, Хашаат, Өгийнуур сумдын нутаг хамаарна.
Судалгааны талбайн солбицол:	<p>1-р талбай:</p> <p>47°13'37.61" 102°46'40.93"          47°33'24.73" 102°29'39.08"          47°35'29.80" 102°47'49.08"          47°14'22.94" 102°58'39.49"</p> <p>2-р талбай:</p> <p>47°33'24.73" 102°29'39.08"          47°48'27.84" 102°31'28.33"          47°48'16.12" 102°43'50.39"          47°35'29.80" 102°47'49.08"</p>
Хуудасны тоо:	6
Ажлын код:	2023-ҮГ/11А
Хөрөнгө оруулалтын эх үүсвэр:	Улсын төсвийн хөрөнгө оруулалт.
Захиалагч байгууллага:	<ul style="list-style-type: none"> <li>- Барилга хот байгуулалтын яам</li> <li>- Шинэ Хархорум хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа</li> </ul>
Зөвшүүлцэх байгууллага:	<ul style="list-style-type: none"> <li>- Байгаль орчин, аялал жуулчлалын яам</li> <li>- Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газар</li> <li>- Шинэ Хархорум хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа</li> </ul>

1.Ажлын даалгаврын үндэслэл:	<ul style="list-style-type: none"> <li>- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 230 дугаар зарлиг “Хархорум хотыг сэргээн байгуулах тухай”;</li> <li>- Монгол Улсын Их Хурлын 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 07 дугаар тогтоол “Орхоны хөндийд Шинэ Хархорум хот байгуулах тухай”;</li> <li>- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтооюур батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого;</li> <li>- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоол “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” батлах тухай;</li> <li>- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 24 дүгээр тогтоол “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” батлах тухай;</li> <li>- Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 38 дугаар тогтоол, “Шинэ Хархорум” хотын бүтээн байгуулалтын үндэсний хороо байгуулах тухай;</li> <li>- Барилга, хот байгуулалтын сайд, Үндэсний хорооны даргын баталсан “Шинэ Хархорум” хотын төлөвлөлт, бүтээн байгуулалтын ажлын хүрээнд хийгдэх эхний ээлжийн арга хэмжээний төлөвлөгөө (2023-2025);</li> <li>- “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”.</li> <li>- Байgal орчин, аялал жуулчлалын Сайдын баталсан Усны нөөцийн зөвлөлийн 2023 оны 1 дүгээр хуралдааны шийдвэр;</li> </ul>
2.Ажлын зорилго, хүрэх үр дүн:	<ul style="list-style-type: none"> <li>- Шинэ Хархорум хотын хүн амын унд ахуйн эх үүсвэрийн зориулалтаар 926л/сек-ээс багагүй газрын доорх усны нөөцийг тогтоох;</li> <li>- Газрын доорх усны нөөцийг үйлдвэрлэлийн зохих зэргээр үнэлэх;</li> <li>- Хүн амьг ундны усны стандартад нийцсэн чанар найрлагатай усаар хангасан байх;</li> <li>- Судалгааны ажлыг үр дүнг Усны нөөцийн зөвлөлөөр хэлэлцүүлж, газрын доорх усны нөөцийг баталгаажуулах;</li> <li>- Ирээдүйн ус авах байгууламжийн бүдүүвчийн оновчтой хувилбарыг боловсруулж, ашиглалтын үйл ажиллагааны горимын талаар мэргэжлийн заавар, зөвлөмж өгөх;</li> <li>- Хүн амьн унд ахуйн ус хангамжийн эх үүсвэрийн нөөц хомсдох, бохирдохоос хамгаалах зорилгоор ус хангамжийн эх үүсвэрт эрүүл ахуйн хоригплолтын болон эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг тогтоох тухай зураглал хийх;</li> <li>- Ус хангамжийн газрын доорх усны эх үүсвэрийн тэжээгдлийн мужийг тогтоох;</li> </ul>
3.Хүчин чадал:	Шинэ Хархорум хотын хүн амын унд ахуйн эх үүсвэрийн зориулалтаар 926л/сек-ээс багагүй газрын доорх усны нөөцийг тогтоох, ус хангамжийн бие даасан эх үүсвэрийг бэлтгэх;

4.Судалгааны ажлын хөтөлбөр:	<p>Газрын доорх усны эрэл-хайгуулын судалгааны ажлын хүрээнд хийж гүйцэтгэх ажлууд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Геологи-гидрогеологийн талбайн маршрутын судалгаа;</li> <li>- Уст цэгийн бүртгэл тооллого;</li> <li>- Талбайн геофизикийн судалгаа цооногийн каротажийн хэмжилт судалгаа;</li> <li>- Гидрогеологийн эрэл, хайгуулын өрөмдлөг;</li> <li>- Шавхалт, туршилтын ажлууд;</li> <li>- Гидрогохимиийн дээжлэлт;</li> <li>- Горимын ажиглалт;</li> <li>- Лабораторийн шинжилгээ;</li> <li>- Геодезийн холболтын ажил;</li> <li>- Суурин боловсруулалт;</li> </ul>
5.Судалгааны ажлын арга зүй, аргачлал, дэс дараалал:	<p>1. <u>Газрын доорх усны эрлийн үе шатанд:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Шинэ Хархорум хотын хүн амын ус хангамжийн эх үүсвэрийг шийдвэрлэхийн тулд агаар сансрын зураг ашиглан, хэрэглэгчдэд хамгийн ойр, усны өсөн нэмэгдэх хэрэгцээг хангах газрын доорх усны хуримтлал бүхий талбайг сонгож дүн шинжилгээ хийх;</li> <li>- Эрлийн судалгааны 2 дэвсгэр талбайн хүрээнд геологи-гидрогеологийн маршрут-ажиглалт, уст цэгийн бүртгэлийг явуулж геоморфологи, структур-тектоникийн байдал геологийн тогтоц, гидрогохимиийн байгалийн суурь нөхцөлтэй газар дээр нь нарийвчлан танилцах;</li> <li>- Гидрогохимиийн судалгааны ажлыг хийхдээ түүх, соёлын дурсгалт зүйлс байгаа талбай, эсхүл шинээр илрүүлсэн тохиолдол бүрд Соёлын өвийг хамгаалах тухай хууль болон холбогдох журмын дагуу түүх, соёлын дурсгалт зүйлсийг хамгаалж ажиллах;</li> <li>- Гидрогохимиийн эрлийн цооног өрөмдөх талбайд урьдчилан археологийн хайгуул судалгаа хийлгэх;</li> <li>- Газрын гадаргуугийн орчин үеийн хотгор, гүдгэрийн дүрс зүйн холбогдох хэмжилт, шаардлагатай бичиглэл, баримтжуулалтыг хийх;</li> <li>- Талбайд орсон гадаргын усны илэрц, булгуудын судалгаа, хэмжилт, дээжлэлтийн ажлуудыг хийх;</li> <li>- Анхан шатны мэдээлэл, баримтыг цуглувлан, агаар сансрын зурагт тайлал, боловсруулалтыг хийж гидрогохимиийн эрлийн шалгуур, шинж тэмдгийг илрүүлэн цаашдын судалгаандаа ашиглах;</li> <li>- Геофизикийн талбайн судалгааг зохих арга аргачлалын дагуу явуулж, газрын доорх усны байгалийн нөөцийн хуримтлал, бөөгнөрөл байж болох тодорхой цэг, усжсан бүсийг тогтоох;</li> <li>- Судалгааны талбайн геологийн тогтоц, гидрогохимиийн нөхцөлийг иж бүрэн үнэлж, хэрэглэгчид хамгийн ойр байх өндөр усжилттай, газрын доорх усны хуримтлал бүхий талбайг сонгон шинээр өрөмдөх цооногуудын байршлыг төлөвлөх;</li> <li>- Гидрогохимиийн эрлийн өрөмлөг, тоноглол, сорьцлолтын шавхалт, гидрогохимиийн дээжлэлтийн ажлыг зохих арга зүй, аргачлалын дагуу хийж, гарсан үр дүнд онолын тайлал, боловсруулалтыг хийх;</li> <li>- Гидрогохимиийн хайгуулын судалгаа явуулах талбай сонгох.</li> </ul>

2. Газрын доорх усны хайгуулын үе шатанд:

- Эрлийн судалгааны ажлын үр дүнд тогтоосон Шинэ Хархорум хотын хүн амын ус хангамжийн эх үүсвэрийг хангах ирээдүйтэй талбайд гидрогеологийн хайгуулын цооногуудыг төлөвлөх;
- Гидрогеологийн хайгуулын цооног өрөмдөх талбайд урьдчилан археологийн хайгуул судалгаа хийлгэх;
- Газрын доорх усны нөөц өгөх талбайн уст давхаргын зузааныг дээжтэй (кернтэй) өрөмдлөг болон цооногийн каротажийн судалгаа хийж, нарийвчлан ялгах;
- Гидрогеологийн хайгуулын цооногт ганцаарчилсан болон багц туршилтын шавхалтын ажлыг 3-5 хоногийн хугацаатай хийх;
- Шавхалтын ажлын үр дүнгээр түвшний бууралт, сэргэлтийн хэмжилтийн өгөгдлүүдийг автомат болон цахилгаан түвшин хэмжигч багажаар хэмжих;
- Гидрогеологийн хайгуулын өрөмдлөг, тоноглол, туршилтын шавхалт болон гидрогоехимиин дээжлэлтийн ажлыг зохих арга зүй, аргачлалын дагуу хийж, гарсан үр дүнд онолын тайлал, боловсруулалтыг хийх;
- Шинэ Хархорум хотын хүн амын ус хангамжийн эх үүсвэрийг хангах ирээдүйтэй талбайг илрүүлсэн тохиолдолд гидрогеологийн эрэл-хайгуулын цооногуудаас сонгон авч газрын доорх усны байгалийн болон эвдэрсэн горимын судалгааг хийх зориулалтаар хяналт шинжилгээний цооног болгон үлдээх (Усны газартай харилцан зөвшилцөх), үлдсэн цооногуудын бэхэлгээний болон шүүрийн яндангийн цувааг сугалж авах;
- Гадаргын ус болон газрын доорх усны шингэн зүйн (гидравликийн) шууд ба шууд бус холбоо, харилцан үйлчлэл байгаа эсэхийг илрүүлэн тогтоох;
- Цаашид хотын ус хангамжийн эх үүсвэрт гадаргын болон газрын доорх усыг хосолсон байдлаар ашиглах боломжийн талаар мэргэжлийн дүгнэлт, зөвлөмж өгөх;
- Эрэл-хайгуулын гидрогеологийн судалгаа явуулж буй талбайд тархсан газрын доорх усны гидрогоехимиин дээжид химийн макро, микро элемент, бактериологийн шинжилгээ, радон, альфа, бетта цацрагийг тодорхойлох лабораторийн шинжилгээг хийж, түүний чанар, химийн найрлагад MNS 900:2018 стандартын дагуу мэргэжлийн үнэлэлт дүгнэлт хийх;
- Гидрогеологийн өрөмдлөг, шавхалт-туршилт хийгдсэн талбайн нөхөн сэргээлт хийж, сумын байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэн өгч, акт үйлдэх;
- Хээрийн ажлын үед хөтөлсөн өрөмдлөгийн журнал болон шавхалт туршилтын ажлын анхдагч материалыудыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Усны газрын нөөцийн хэлтэст хүлээлгэн өгөх гэх мэт.

Суурин боловсруулалт:

- Гидрогеологийн эрэл-хайгуулын судалгааны ажлын үр дүнгийн тайланг БОНХАЖС-ын 2015 оны А-173 дугаар тушаалаар батлагдсан “Газрын доорх усны нөөцийг хүлээн авах ангилал, зэрэглэл”-ийн аргачилсан

	зааврын дагуу боловсруулж, БОАЖЯ-ны Усны нөөцийн зөвлөл болон Барилга хот байгуулалтын яамны Шинжлэх ухаан, техник технологийн зөвлөлд хэлэлцүүлэх.
6.Мөрдөх хууль, тогтоомж, стандарт, журам, эрх зүйн орчин:	<p>Хууль тогтоомжууд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Монгол Улсын Үндсэн хууль;</li> <li>- Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль;</li> <li>- Усны тухай хууль;</li> <li>- Газрын тухай хууль;</li> <li>- Соёлын өвийгт хамгаалах тухай хууль;</li> <li>- Ашигт малтмалын тухай хууль;</li> <li>- Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль;</li> <li>- Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль;</li> <li>- Тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг</li> </ul>
7.Гүйцэтгэгч байгууллага:	Байгаль орчин, аялал жуучлалын яамнаас усны хайгуул судалгаа хийх тусгай зөвшөөрөлтэй усны мэргэжлийн байгууллагууд.
8.Тавигдах шаардлага, тусгай нөхцөл:	<ul style="list-style-type: none"> <li>- Захиалагч байгууллагаар хээрийн ажлын явц, гүйцэтгэлийг хяналт хийлгүүлж, баталгаажуулах;</li> <li>- Усны газрын даргын тушаалаар томилсон шинжээчид судалгааны ажлын арга аргачлал, гүйцэтгэлд мэргэжлийн дүгнэлт өгөх зорилгоор хээрийн судалгааны ажлын явцад 2-оос доoshгүй удаа хөндлөнгийн хяналт хийх бөгөөд зардлыг гүйцэтгэгч байгууллага хариуцна;</li> <li>- Эрэл-хайгуулын судалгаа хийх өрөмдлөгийн цэгт Археологийн хайгуул судалгаа хийлгэх;</li> </ul>

ХЯНАСАН:

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЧЛАЛЫН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА



S.ЦОГТГЭРЭЛ

ШИНЭ ХАРХОРУМ ХОТЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АСУУДАЛ  
ХАРИУЦСАН ЗАХИРГААНЫ ДАРГА




Н.НАЦАГДОРЖ

УСНЫ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

3.БАТБАЯР

УСНЫ ГАЗРЫН УСНЫ НӨӨЦИЙН ХЭЛТСИЙН ДАРГА




Ч.ПУНЦАГСҮРЭН

ШИНЭ ХАРХОРУМ ХОТЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АСУУДАЛ  
ХАРИУЦСАН ЗАХИРГААНЫ ХОТ ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН




ХОСБАЯР

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЧЛАЛЫН ЯАМНЫ БАЙГАЛИЙН  
НӨӨЦИЙН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН




Т.ДАВААНЯМ

УСНЫ ГАЗРЫН УСНЫ НӨӨЦИЙН ХЭЛТСИЙН АХЛАХ  
МЭРГЭЖИЛТЭН



Д.ТУВШИНЖАРГАЛ

БОЛОВСРУУЛСАН:



Б.МОНГӨНТУУЛ

УСНЫ ГАЗРЫН УСНЫ НӨӨЦИЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН



М.ОТГОНБАТ - 2

ШИНЭ ХАРХОРУМ ХОТЫН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АСУУДАЛ  
ХАРИУЦСАН ЗАХИРГААНЫ ХОТ ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН  
ИНЖЕНЕР

